

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СБА-2021/1/СТА-ТЕЗ

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун-Урт
2021 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Болдбаатар

Аудитор: А.Мөнхцэцэг, Б.Мөнхбамбар

Утас: 70512127 Цахим хаяг: Boldbaatarn@audit.gov.mn

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.1. Аудитын тайлан.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдлын сүүрх сонгосон үндэслэл, тайлбар.....	11
3.5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
3.5.2 Авлага.....	13
3.5.3 Бараа материал	14
3.5.4 Урьдчилгаа.....	15
3.5.5 Үндсэн хөрөнгө	15
3.5.6 Өр төлбөр.....	17
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	18
3.5.8 Орлогын данс	19
3.5.9 Зардал	19
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга	20
3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	22
3.8. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	23
3.9. Шилэн дансны мэдээлэл	24
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	24
3.11. Аудитын зөвлөмж	24
3.12. Холбогдох байгууллагын санал:.....	25
3.13. тайлан баталагаажуулсан тушаал:.....	27
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
БСШУС	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд
БТСГ	Биеийн тамир спортын газар
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БЭМДС	Боловсрол, эрүүл мэндийг дэмжих сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УОО	Урьдчилж орсон орлого
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮТП	Үйлдвэр, технологийн парк
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
М.ИДЭРБАТ ТАНАА

2021.04.28 № 167
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлан, сургалтын төлөвлөгөө, стратегийн баримт бичиг болон удирдлагын гаргадаг мэдээллийг аудитад судлан, дүн шинжилгээ хийхэд санхүүгийн тайлангуудтай материаллаг хэмжээгээр зөрчилдөж байгаа зүйл илэрсэнгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,286,181.40	20,854,687.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,002,370.20	9,408,301.60
33	АВЛАГА	5,486,490.80	5,611,416.40
34	УРЬДЧИЛГАА	5,092.00	143,339.80
35	БАРАА МАТЕРИАЛ	5,651,294.90	5,563,507.20
36	НӨӨЦИЙН БАРАА	71,148.20	65,802.20
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	69,785.30	62,320.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	93,807,732.20	105,205,416.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	93,807,732.20	105,205,416.80
39200	Биет хөрөнгө	89,704,128.50	100,933,577.60
39300	Биет бус хөрөнгө	4,089,018.40	4,262,118.90
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14,585.30	9,720.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	110,093,913.60	126,060,104.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,865,336.30	27,595,825.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,471,284.90	20,757,976.50
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,151,352.30	1,221,536.20
41300	Өглөг	3,388,812.00	2,261,563.60
41400	Урьдчилж орсон орлого	12,931,120.60	17,274,876.60
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,394,051.40	6,837,849.30
42200	Урт хугацаат зээл	4,394,051.40	6,837,849.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	88,228,577.20	98,464,278.50
51	Засгийн газрын хувь оролцоо	88,228,577.20	98,464,278.50
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59,663,375.00	59,343,906.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	643,243.80	990,669.30
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0	820.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	231,207.20	231,207.20
51200	Хуримтлагдсан үр дүн	2,517,259.20	12,967,069.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,173,492.00	24,930,606.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	110,093,913.60	126,060,104.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

		/Мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	134,806,315.20	97,862,125.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	9,014,093.20	9,051,984.90
110	Орлогын албан татвар	6,383,281.10	6,692,489.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,918,192.50	7,157,374.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-534,911.40	-464,884.80
113	Хөрөнгийн албан татвар	1,022,931.50	1,061,949.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,607,880.60	1,297,546.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,880,260.60	78,844,989.60
120	Нийтлэг татварын бус орлого	16,261,898.40	23,828,986.70
121	Хөрөнгийн орлого	26,193.50	46,754.50
122	Тусламжийн орлого	9,547.20	7,394.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	38,582,621.50	54,961,854.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,911,961.40	9,965,150.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	125,471,708.60	76,833,366.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,471,708.60	76,833,366.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,476,240.10	70,906,020.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,344,401.70	32,168,781.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,405,087.60	4,057,381.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,574,856.30	4,390,909.40
2104	Хангамж, бараа материалын зардал	9,352,901.80	9,543,561.80
2105	Нормативт зардал	2,322,148.20	2,302,973.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	993,799.80	516,449.50
2107	Томилолт, зочны зардал	326,452.60	89,222.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,102,748.00	5,665,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,053,844.20	12,171,341.10
212	ТАТААС	496,997.30	500
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,498,471.20	5,926,846.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,334,606.60	21,028,758.50
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	24,349.70	10,235.40
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,882,598.80	10,850,009.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,476,357.50	10,188,984.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	137,144,093.60	92,118,962.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	9,014,093.20	9,049,984.70
110	Орлогын албан татвар	6,383,281.10	6,690,489.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,918,192.50	7,155,374.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-534,911.40	-464,884.80
113	Хөрөнгийн албан татвар	1,022,931.50	1,061,949.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,607,880.60	1,297,545.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	315,949.20	294,780.30
1181	Газрын төлбөр	221,815.80	472,932.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,018,114.30	508,393.80
1183	Бусад татвар	52,001.30	21,439.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,456,291.30	73,058,419.70
120	Нийтлэг татварын бус орлого	17,834,929.10	18,042,416.80
121	Хөрөнгийн орлого	29,193.50	46,754.50
122	Тусламжийн орлого	9,547.20	7,394.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	38,582,621.50	54,961,854.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,673,709.10	10,010,558.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,912,026.80	67,440,713.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,912,026.80	67,440,713.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,358,716.10	63,932,458.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,613,455.90	34,925,453.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,123,329.70	4,963,545.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,044,607.80	5,522,174.80
2104	Хангамж, бараа материалын зардал	5,459,339.30	5,776,377.80
2105	Нормативт зардал	2,404,068.10	2,365,092.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	947,644.20	578,300.30
2107	Томилолт, зочны зардал	320,545.20	91,051.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,659,057.10	4,334,175.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,786,668.80	5,376,286.90
212	ТАТААС	496,997.30	500
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,056,313.40	3,507,755.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,232,066.70	24,678,249.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	101,989.00	28,862.00

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,477,742.00	19,371,564.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,477,742.00	19,371,564.90
2200	Дотоод эх үүсвэрээр	15,477,742.00	19,371,564.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,375,753.00	-19,342,703.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,224,882.40	-929,614.80
14	Бусад эх үүсвэр	76,552.20	38,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	871,323.80	824,550.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	430,110.80	143,064.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,631,431.40	4,405,931.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,370,938.90	5,002,370.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,002,370.20	9,408,301.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,358,645.20	0	88,358,645.20
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,386,062.80	0	2,386,062.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,744,707.90	0	90,744,707.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-63,748.00	0	-63,748.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-540,788.00	0	-540,788.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	-3,387,952.20	0	-3,387,952.20
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	1,476,357.50	0	1,476,357.50
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,228,577.20	0	88,228,577.20
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	88,228,577.20	0	88,228,577.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	246,558.90	0	246,558.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,475,136.20	0	88,475,136.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-242,885.30	0	-242,885.30
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	43,042.70	0	43,042.70
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	10,188,984.90	0	10,188,984.90
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	98,464,278.50	0	98,464,278.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,231,018.9	65,980,205.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,042,951.4	53,868,795.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,509,055.4	52,569,122.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,292,022.2	31,624,246.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,124,541.0	4,048,564.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,182,607.6	4,941,329.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,302,358.9	1,242,767.9
2105	Нормативт зардал	2,880,611.9	2,203,421.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	938,494.4	733,451.6
2107	Томилолт, зочны зардал	155,450.5	75,094.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,283,718.4	2,058,540.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,349,250.5	5,641,706.5
212	ТАТААС	251,997.3	251,997.3
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	107,233.8	107,233.8
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	144,763.5	144,763.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,281,898.7	1,047,675.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,281,898.7	1,047,675.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,428,272.5	11,286,860.2
2200	Дотоод эх үүсвэрээр	13,428,272.5	11,286,860.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,759,795.0	824,550.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	73,231,018.9	67,322,891.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,776,127.8	43,320,315.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,838,642.3	22,051,292.1
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	369,008.3	303,930.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,247,240.5	1,647,354.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,654,105.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	2,995,667.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	102	102
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	2860	2794
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	17710	16919
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	11419	10895
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	6291	6024
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	4518	3024

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2860	2794
----	---------------------	------	------

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны Гүйцэтгэл	Тайлант оны Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,068,378.7	4,338,529.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,328,455.3	4,006,477.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,919,022.0	3,033,084.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,501.5	92,835.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,902.5	13,306.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,963.0	13,318.8
2104	Хангамж, бараа материалын зардал	176,678.5	129,559.3
2105	Нормативт зардал	43,497.3	120,735.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	197,230.5	167,838.0
2107	Томилолт, зочны зардал	120,955.2	13,587.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,280,212.4	1,006,988.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,312,081.2	1,474,914.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	409,433.3	973,392.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,802.2	973,392.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,739,923.4	39,550.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,739,923.4	39,550.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,068,378.7	4,338,529.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,068,378.7	4,338,529.2

3.1. АУДИТЫН ТАЙЛАН

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга М.Идэрбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 4 дүгээр сарын 01-нээс 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор А.Мөнхцэцэг, Б.Мөнхбамбар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2021.3.29-нд төрийн аудитын байгууллагад 6/355 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, уул уурхай дагасан дэд бүтцийн хөгжлийг дэмжин, нийгмийн салбаруудын үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах замаар хувь хүний хөгжил, боловсрол, өрх гэр бүлийн амьдралыг сайжруулах бодлого үйл ажиллагааг түлхүү хэрэгжүүлэх”-д оршино.

Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого
- Нийгмийн хөгжлийн бодлого
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын хөгжлийн бодлого
- Засаглалын бодлого

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2009 онд боловсруулсан, нэмэлт өөрчлөлт, стандартын өөрчлөлттэй холбогдуулан шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад заавар, журам, стандартыг мөрдөхгүй байх зэрэг үр дагавартай байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 онд Засаг даргын харьяа төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-ын нийт 52 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдан авалтын чиглэлээр нийт 131 зөвлөмж, 21 албан шаардлага, 60 төлбөрийн акт тогтоосон байна. Төлбөрийн актын биелэлт 48.0 хувьтай, өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг тооцоогүй байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,071.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч өмнөх оноос 2,322.0 сая төгрөгөөр өссөн нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснийг илтгэж байна.

3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 64,617.6 сая төгрөгийн 2 хувь буюу 1,292.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 76,833.4 сая төгрөгийн 1.5 хувь буюу 1,152.5 сая төгрөгөөр тогтоосон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлсэнтэй холбоотой болно.

3.5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,002.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,408.3 сая төгрөг болж, 4,405.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	15.1	10.4	-4.7
Банканд байгаа бэлэн мөнгө	4,987.3	9,397.9	4,410.6
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
Дүн	5,002.4	9,408.3	4,405.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,654.1	2,995.7	1,341.6
Төсөл/ сан	984.2	3,801.5	2,817.3
Төрийн сан	2,133.6	2,358.7	225.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	230.5	252.4	21.9
Дүн	5,002.4	9,408.3	4,405.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 2,995,7 сая төгрөг төсөвт байгууллага, 3,801.5 сая төгрөг төсөл сангийн үлдэгдэл, 252.4 сая төгрөг орон нутгийн өмчит байгууллага, 2,358.7 сая төгрөг Төрийн сангийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн дансны үлдэгдлийн 2,332.2 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий дансны үлдэгдэл, сангийн 1,968.7 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сан, Замын сан, Боловсрол, эрүүл мэндийг дэмжих сангийн үлдэгдэл байгаа бол 1,026.9 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл, 665.4 сая төгрөг нь УТХО-ын дансны үлдэгдэл, 3,136.1 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 220.9 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрч 37.6 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 183.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө. Үүнд:

- Анхан шатын баримтын иж бүрдэл бүрэн хангагдаагүй ажил үйлчилгээг санхүүгийн тайланд тусгасан, Луртын гэгээ ОНӨААТҮГ 66.5 сая төгрөг, Сүхбаатар хөгжил ҮТП ОНӨААТҮГ 12.8 сая төгрөг, Баруун-Урт сум ИТХ 14.0 сая төгрөг/
- Бэлэн мөнгөний үлдэгдэлд сар бүр тооллого хийж тооцоог бодон, үр дүнг баталгаажуулдаггүй /Сүхбаатар хөгжил ҮТП/
- Шүлхийн зардлаас үлдсэн хөрөнгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэлгүй, орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн /Баруун-Урт сум ЗДТГ 32.6 сая төгрөг/
- Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлаас бэлтгэсэн материалыг дансанд орлого авч бүртгэлгүй зарцуулсан. /Баруун-Урт сум ЗДТГ 3.8 сая төгрөг/

- Мөрийн хөтөлбөрийн зардлаас бэлтгэсэн материалыг данс бүртгэлд бүртгээгүй зарцуулсан. /Баруун-Урт сум ЗДТГ 90.0 сая төгрөг/
- Ээлжийн амралтын хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөн үедээ бензин шатахууны төлбөрийг байгууллагаас төлүүлсэн. /Сүхбаатар хөгжил УТП ОНӨААТҮГ 1.2 сая төгрөг/

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 5,486.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,611.4 сая төгрөг болж, 125.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	9.4	50.1	40.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	109.6	114.6	5.0
Татаас, санхүүжилтийн авлага	13.9	0	-13.9
Зээлийн хүүгийн авлага	46.8	59.6	12.8
Дансны авлага /ТӨҮГ/	1,626.0	1,812.7	186.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	46.3	64.4	18.1
Бусад авлага	3,371.9	3,216.3	-155.6
Зээлийн авлага	262.5	293.7	31.2
Дүн	5,486.4	5,611.4	125.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	3,296.8	3,208.8	-88.0
Төсөл/ сан			
Төрийн сан	106.4	97.2	-9.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,083.2	2,305.4	222.2
Дүн	5,486.4	5,611.4	125.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 57.2 хувь буюу 3,208.8 сая төгрөг төсөвт байгууллагын, 41.1 хувь буюу 2,305.4 сая төгрөг нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 1.7 хувь буюу 97.2 сая төгрөг төрийн сангийн авлага байна.

Төсөвт байгууллагын нийт авлагын 91.7 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага эзэлж байгаа бөгөөд тайлант онд шинээр 824.6 сая төгрөгийн зээл олгосон нь нөлөөлсөн байна.

Харин орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд дахь нийт авлагын 40.8 хувь буюу 940.7 сая төгрөг Сүхбаатар үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ-ын зээлийн авлага, 35.6 хувь буюу 821.6 сая төгрөг Дөрвөлж ОНӨААТҮГ-ын авлага эзэлж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 8.9 хувь буюу 501.4 сая төгрөг нь олон жилийн насжилттай авлага байна. Эдгээр нь эргэн төлөгдөхгүй байх, төсвийн хөрөнгө үрэгдэх, найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бий болгосон эрсдэлтэй байна. Олон жилийн насжилттай авлагын 77.6 хувь буюу 389.0 сая төгрөг сум хөгжүүлэх сангаас 2012-2016 онуудад олгосон зээл, зээлийн хүүгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагатай холбоотой Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 179.4 сая төгрөгийн 16 алдаа, зөрчил илэрч 57.7 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 7.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 113.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өглөө. Үүнд:

- Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн дансанд төвлөрүүлэлгүй харилцагч байгууллагад шилжүүлэн, бодит бус авлага үүсгэсэн /8 төсвийн шууд захирагч 31.8 сая төгрөг/
- Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн зээлийн гэрээний хугацаа дууссан боловч зээлийн үндсэн төлөлт, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй

/Баяндэлгэр сум СХСан 24.6 сая төгрөг/

- *Нүүрс тээвэрлэлтийн хөлс олгохдоо жишиг нормативыг мөрдөөгүй. /Түвшинширээ сум ЭМТ 1.2 сая төгрөг/*
- *Он дамжсан авлагыг барагдуулах чиглэлээр удирдлага зохион байгуулалт хийж ажиллаагүй, авлагыг нэмэгдүүлсэн /Жаахан шарга театр 7.8 сая төгрөг/*
- *Зарим дансны авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /Дөрвөлж ОНӨААТҮГ/*
- *Харилцагч байгууллагуудын авлагыг тус бүрээр үүсгэлгүй нэг байгууллага дээр бүртгэсэн. /Баруун-Урт сум ЗДТГ 113.8 сая төгрөг/*
- *Өмнөх онуудад барагдуулаагүй эзэн холбогдогч нь тодорхойгүй он удаан жил болсон авлагыг барагдуулаагүй /Дөрвөлж ОНӨААТҮГ, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ/*

3.5.3 Бараа материал

Бараа материалын оны эхний үлдэгдэл 5,651.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,563.5 сая төгрөг болж, 87.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,214.2	589.3	-624.9
Дуусаагүй үйлдвэрлэл	467.8	518.1	50.3
Бэлэн бүтээгдэхүүн	4.9	2.6	-2.3
Хангамжийн материал	3,690.3	4,124.3	434.0
Биологийн хөрөнгө	43.1	-	-43.1
Мал амьтад	231.0	329.2	98.2
Дүн	5,651.3	5,563.5	-87.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4,830.1	4,578.9	-251.2
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	821.2	984.6	163.4
Дүн	5,651.3	5,563.5	-87.8

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 8,756.3 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй буюу хандиваар 258.3 сая төгрөг, шилжүүлэн авсан 158.7 сая төгрөг, бусад 660.3 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 8,835.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1,092.2 сая төгрөгийг акталж, шилжүүлсэн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 81 хувийг төсөвт байгууллага, 19 хувийг ОНӨААТҮГ эзэлж байна.

Бараа материалын дуусаагүй үйлдвэрлэл дансанд Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4 сургуулийн түрээсийн ном 61.8 сая төгрөг, мөн Баруун-Урт сумын ОНХС-аар хэрэгжсэн дуусаагүй 4 төсөл арга хэмжээний 449.5 сая төгрөг, Эрдэнэцагаан сумын Чоногол хөгжил ОНӨААТҮГ хангамжийн бараа материалын үлдэгдэл 6.7 сая төгрөг тус тус бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой нийт 301.9 сая төгрөгийн 34 алдаа, зөрчил илэрч 71.4 сая төгрөгийн зөрчилд 16 төлбөрийн акт тогтоож, 179.3 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 51.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 9 зөвлөмж өглөө. Үүнд:

- *Хоолны зардлаас хэмнэгдсэн хөрөнгө нь төсвийн хэмнэлтэд тооцогдоогүй бөгөөд төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, хүнсний материал нөөцөлсөн зөрчил дутагдал илэрсэн. /16 төсвийн шууд захирагч 71.4 сая төгрөг/*
- *Бараа материалын тайланг сар бүр гаргадаггүй, хөрөнгийн тооллогыг хийж баталгаажуулаагүй /Чоногол хөгжил ОНӨААТҮГ, Сүхбаатар ойжуулалт ОНӨААТҮГ, Сүхбаатар*

хөгжил ҮТП 18.2 сая төгрөг, Түмэнцогт сум ЕБС 52.7 сая төгрөг/

- *Нүүрс тээвэрлэлтийн хөлс олгохдоо жишиг нормативыг мөрдөөгүй. /Түвшинширээ сум Цэцэрлэг 1.3 сая төгрөг/*
- *Бараа материалыг шууд зардлаар илэрхийлсэн /Сүхбаатар хөгжил ҮТП 12.8 сая төгрөг/*
- *Өмнөх жилийн тээврийн хөлсийг нүүрсний өртөгт шингээж зардлаар илэрхийлээгүй /Түмэнцогт Ус дулаан ОНӨААТҮГ 27.8 сая төгрөг/*
- *Төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиг багатай зүйлд зарцуулсан /Лулбаян сум ЭМТ 0.6 сая төгрөг, Цэцэрлэг 1.5 сая төгрөг/*
- *Анхан шатны баримтын иж бүрдэл бүрэн хангагдаагүй ажил үйлчилгээг санхүүгийн тайланд тусгасан /Түвшинширээ сум ЭМТ 1.1 сая төгрөг, Боловсрол өргөө дотуур байр 1.0 сая төгрөг/*
- *Бараа материалын тайланг сар бүр гаргадаагүй бөөн дүнгээр тайланд илэрхийлсэн /Баруун-Урт сум 3,7-р цэцэрлэг, Түмэнцогт сум ЕБС 14.2 сая төгрөг/*

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 5.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 143.3 сая төгрөг болж, 138.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3.9	142.8	138.9
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.3	-	-0.3
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа	0.9	0.5	0.4
Томилолтын урьдчилгаа			
Дүн	5.1	143.3	138.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1.2	2.8	1.6
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	3.9	140.5	136.6
Дүн	5.1	143.3	138.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын цалингийн урьдчилгаа БТСГ 0.5 сая төгрөг, ХЖТ 2.1 сая төгрөг, Музей 0.1 сая төгрөг, Номын сан 0.1 сая төгрөг байна.

Харин 140.3 сая төгрөг Дөрвөлж ОНӨААТҮГ-ын бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа төлбөр байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 93,807.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 105,205.3 сая төгрөг болж, 11,397.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	70,444.9	85,598.3	15,153.4
Хуримтлагдсан элэгдэл	-5,354.6	-10,090.1	-4,735.5
Тээврийн хэрэгсэл	7,331.9	7,700.0	368.1
Хуримтлагдсан элэгдэл	-4,757.7	-5,019.0	-261.3
Машин тоног төхөөрөмж	15,695.1	16,958.6	1,263.5
Хуримтлагдсан элэгдэл	-10,022.0	-11,112.9	-1,090.9
Тавилга эд хогшил	5,686.0	6,125.3	439.3

Хуримтлагдсан элэгдэл	-3,678.7	-4,032.1	-353.4
Зам гүүрийн байгууламж	95.8	344.1	248.3
Хуримтлагдсан элэгдэл	-16.7	-33.1	-16.4
Түүх соёлын дурсгалт зүйл	1,152.2	1,172.8	20.6
Дуусаагүй барилга байгууламж	2,424.5	2,424.5	0.0
Номын фонд	729.7	785.8	56.1
Бусад үндсэн хөрөнгө	15,979.0	17,422.5	1,443.5
Хуримтлагдсан элэгдэл	-6,005.4	-7,311.1	-1,305.7
Программ хангамж	106.6	115.8	9.2
Хуримтлагдсан элэгдэл	-64.3	-70.3	-6.0
Бусад биет бус хөрөнгө	4,061.1	4,228.7	167.6
Хуримтлагдсан элэгдэл	-14.3	-12.2	2.1
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14.6	9.7	-4.9
Дүн	93,807.7	105,205.3	11,397.6
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	63,339.5	71,763.4	8,423.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	30,468.2	33,441.9	2,973.7
Дүн	93,807.7	105,205.2	11,397.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 68.2 хувь төсөвт байгууллагууд, 31.8 хувь ОНӨААТҮГ-ын хөрөнгүүд эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,227.1 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 6,327.9 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 8,704.1 сая, шилжүүлэн авсан 6,762.8 сая, бусад 5,520.5 сая нийт 22,214.6 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 212.7 сая, балансаас баланст шилжүүлсэн 1,128.9 сая, акталсан 1,708.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламж дансанд 578.0 сая төгрөгийн Баруун-Урт сумын үерийн сувгийн байгууламж улсын комисс хүлээн аваагүй, 1,602.5 сая төгрөгийн 700 хүний суудалтай Спорт цогцолборын барилгын хөрөнгө царцаагдсан холбоотой нийт 2,424.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 3,833.1 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илрүүлснээс 3,833.1 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 400 хүний суудалтай усан бассейны барилгыг данс бүртгэлд тусгаагүй /БТСГ 3,758.8 сая төгрөг/
- Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй зарим тоног төхөөрөмж болон талбайг түрээслэгчдэд үнэ төлбөргүй ашиглуулж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй байлгах нөхцөлийг бүрдүүлсэн /БТСГ/
- Биеийн тамир спортын газрын "Б" заалны барилгын, хоккейн талбай, хөл бөмбөгийн талбайн газрууд газар эзэмших эрхийн гэрчилгээгүй, санхүүгийн бүртгэл тайланд бүртгэж толилуулаагүй байна./БТСГ/
- Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн хийж баримтжуулаагүй, тооллогын дүнг тулгаж, баталгаажуулаагүй. /Дарьганга сумын ЗДТГ 72.9 сая төгрөг, Наран сум ЗДТГ, Мөнххаан сум Соёл/
- Төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиг багатай зүйлд зарцуулсан / Баруун-Урт сум 4-р цэцэрлэг/

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл богино хугацаат өр төлбөр 17,230.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 17,471.3 сая төгрөг болж, 241.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	17,471.3	20,757.9	3,286.6
Богино хугацаат зээлийн өглөг	1,151.4	1,221.5	70.1
Өглөг	3,388.8	2,261.6	-1,127.2
Ажиллагчидтай холбогдсон өглөг	139.9	111.1	-28.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	114.1	16.0	-98.1
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	6.0	2.1	-3.9
Бусад өглөг	3,128.8	2,132.4	-996.4
Байгууллагад төлөх өглөг	2,072.8	1,415.1	-657.7
Хувь хүмүүст төлөх өглөг	186.2	113.3	-72.9
Татварын өглөг /ТӨҮГ/	568.4	290.7	-277.7
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	105.3	33.6	-71.7
Дансны өглөг /ТӨҮГ/	196.1	279.7	83.6
Урьдчилж орсон орлого	12,931.1	17,274.8	4,343.7
Бусад урьдчилж орсон орлого	12,542.6	16,598.2	4,055.6
ТӨҮААГ	388.5	676.6	288.1
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	4,394.0	6,837.8	2,443.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	4,394.0	6,837.8	2,443.8
Нийт дүн	21,865.3	27,595.7	5,730.4
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	17,471.3	20,757.9	3,286.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,449.0	872.7	-576.3
Төрийн сан	104.3	30.9	-73.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	15,918.0	19,854.3	3,936.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>	4,394.0	6,837.8	2,443.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,394.0	4,394.0	-
Төсөвт байгууллага	-	2,443.8	2,443.8
Нийт дүн	21,865.3	27,595.7	5,730.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дүн 3,286.6 сая төгрөгөөр өсөхөд богино хугацаат зээлийн өглөг 70.1 сая, дансны өглөг /ТӨҮГ/ 83.6 сая, урьдчилж орсон орлогын 4,343.7 сая төгрөг тус тус нөлөөлсөн бол байгууллагад төлөх өглөг 657.7 сая төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 72.9 сая төгрөг, ажиллагсад болон бараа үйлчилгээ, хөрөнгөтэй холбоотой өглөг 130.8 сая төгрөг, Татвар, НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ 349.4 сая төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн 95.7 хувь буюу 19,854.3 сая төгрөг орон нутгийн өмчит хуулийн этгээд, 4.2 хувь буюу 872.7 сая төгрөг төсөвт байгууллагын, 0.2 хувь буюу 30.9 сая төгрөгийг төрийн сангийн өр төлбөр тус тус эзэлж байна.

Урьдчилж орсон орлого 4,343.7 сая төгрөгөөр өссөн нь ОНӨААТҮГ-т орон нутгийн өмчийг эзэмшүүлж, СТОУС-ын дагуу орлогын аргаар бүртгэсэн нь богино хугацаат өр төлбөрийг өсөхөд нөлөөлсөн байна. Үүнд:

Байгууллагын нэр		Хүснэгт №7 Дүн /сая төгрөг/
1	Дөрвөлж ОНӨААТҮГ	1,906.8
2	Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	118.2
3	Сүхбаатар ойжуулалт ОНӨААТҮГ	38.0
4	Сүхбаатар хөгжил ҮТП ОНӨААТҮГ	322.6
5	Түмэнцогт ОНӨААТҮГ	30.9
6	Түмэнцогт Ус дулаан ОНӨААТҮГ	87.0
7	Онгон арвижих ОНӨААТҮГ	1,519.1
8	Чоно хөгжил ОНӨААТҮГ	65.5
9	Уртын гэгээ ОНӨААТҮГ	897.9
10	Хайлааст голомт ОНӨААТҮГ	767.2

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Дөрвөлж ОНӨААТҮГ-ын Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн 4,394.0 сая төгрөгийн өглөгтэй байна. /МОН-1907 гэрээ 2003-2008/ 3,068.3 сая төгрөг, МОН-2301 гэрээ 2011-2013/ 1,325.7 сая төгрөг/

Тайлант онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд “Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 2,443.7 сая төгрөгийн зээлийг бүртгэсэн байна. /L3713-МОН гэрээ №2019/293/

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөртэй холбоотой нийт 104.7 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрч, 72.0 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 32.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө. Үүнд:

- Өр төлбөрийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, данс бүртгэлд тусгасан / Түмэнцогт сум ЕБС 3.2 сая төгрөг/
- Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, өр төлбөр үүсгэсэн /6 төсвийн шууд захирагч 68.8 сая төгрөг/

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 88,228.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 98,464.2 сая төгрөг болж, 10,235.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Засгийн газрын оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн + Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал	59,663.4	59,343.9	-319.5
Өмч /ТӨҮГ/	643.2	991.4	348.2
Эздийн өмчийн бусад хэсэг	231.2	231.2	-
Хуримтлагдсан үр дүн	2,517.3	12,967.1	10,449.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,173.5	24,930.6	-242.9
Дүн	88,228.6	98,464.2	10,235.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	72,045.6	79,542.8	7,497.2
Төсөл, сан	984.2	3,801.5	2,817.3
Төрийн сан	1,903.8	2,241.0	337.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	13,295.0	12,878.9	-416.1
Дүн	88,228.6	98,464.2	10,235.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс нөлөөлжээ.

Орон нутгийн өмч 348.2 сая төгрөгөөр өссөн нь Бичигт Их Өргөө ОНӨААТҮГ 532.7 сая төгрөгөөр хөрөнгийг шилжүүлж авсан харин Номын сан 185.3 сая төгрөгийн хөрөнгийг Өмч /ТӨҮГ/ дансанд бүртгэсэн байсныг Засгийн газрын капитал данс руу шилжүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд 9 төсөвт байгууллага дахин үнэлсэн үндсэн хөрөнгө акталж устгаснаас хөрөнгийн дахин үнэлгээ 242.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.8 Орлогын данс

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны орон нутгийн нэгдсэн татварын орлогыг 8,161.6 сая төгрөг, татварын бус орлогыг 4,186.7 сая төгрөг, хөрөнгийн орлогыг 50.0 сая төгрөг нийт 12,398.3 сая төгрөгөөр баталжээ.

Нэгтгэсэн тайланд татварын орлого 9,049.9 сая төгрөг, татварын бус орлого 3,003.6 сая төгрөг, хөрөнгийн орлого 46.8 сая төгрөг нийт 12,341.6 сая төгрөг төвлөрчээ.

Гүйцэтгэлээр татварын орлого 111 хувь, татварын бус орлого 77.5 хувьтай биелсэн байна. Нийт орлогын гүйцэтгэл 12,341.6 сая төгрөг буюу төсвийн орлого 56.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Орлого данстай холбоотой нийт 4.3 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрч, 0.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өглөө. Үүнд:

- Үйлчилгээний орлогыг дутуу бүртгэж, тайланд тусгаагүй /Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 0.8 сая төгрөг/
- Орлогын үлдэгдэлд сар бүр тооллого хийж тооцоог бодож, үр дүнг баталгаажуулдаггүй /Мөнххаан сум Соёл 2.6 сая төгрөг/
- Орон нутгийн өмчийг түрээслүүлсний төлбөр дутуу төвлөрүүлсэн /БТСГ 0.8 сая төгрөг/

3.5.9 Зардал

Бараа үйлчилгээний зардал өмнөх оноос 12.0 хувь буюу 7,619.8 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 4.4 дахин буюу 4,595.4 сая төгрөгөөр тус тус өсжээ.

Хүснэгт №9 /сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн + Буурсан -
Бараа, ажил үйлчилгээний зардал	63,286.20	70,906.00	7,619.80
Татаас	-	0.5	0.5
Урсгал шилжүүлэг	1,331.40	5,926.80	4,595.40
Дүн	64,617.60	76,833.30	12,215.70
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	56,339.80	66,641.20	10,301.40
Төсөл, сан	2,812.00	3,839.60	1,027.60
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	5,465.70	6,352.40	886.7
Дүн	64,617.50	76,833.30	12,215.70

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа үйлчилгээний зардлын өсөлт нь төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн, шүүхийн шийдвэрийн дагуу олгосон хэлмэгдүүлэлтийн цагаатгалын нөхөн олговор олгосон, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зардлын өсөлтөөс шалтгаалжээ.

Харин урсгал шилжүүлгийн зардал Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-с 2,443.8 сая төгрөгийн хөрөнгийн зардлын санхүүжилттэй холбоотойгоор өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

Зардал данстай холбоотой нийт 221.1 сая төгрөгийн 103 алдаа, зөрчил илэрч 168.8 сая төгрөгийн зөрчилд 80 төлбөрийн акт тогтоож, 52.4 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө. Үүнд

- Цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал буруу тооцож, олгосон /49 төсвийн шууд захирагч 168.8 сая төгрөг/
- Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд төсвийн захирагч ажилд эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй /Аймгийн ЗДТГ 32.6 сая төгрөг, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 5.1 сая төгрөг/
- Өвчтөний хоол хүнсэнд хэрэглэгдэхгүй бараа материал худалдан авч, хоолны зардлыг илүү зарцуулсан. /Баяндэлгэр сум ЭМТ 0.3 сая төгрөг/
- Өвчтөний хоолны материалаас махыг норм хэтрүүлэн илүү олгосон. /Сүхбаатар сум ЭМТ 0.7 сая төгрөг/
- Анхан шатны баримтыг хуурамчаар үйлдэн зарцуулалт гаргасан. /Байгаль орчны аялал жуулчлалын газар 9.1 сая төгрөг, Насан туршийн боловсрол 4.2 сая төгрөг/
- Ээлжийн амралтаа биеэр эдлээгүй 2 ажилтанд мөнгөн урамшууллыг олгоогүй. /Дарьганга сум ЗДТГ 6.9 сая төгрөг, Сүхбаатар хөгжил ҮТП ОНӨААТҮГ 1.5 сая төгрөг/
- Нүүрсний тээврийн хөлсийг илүү бодож олгосон /Асгат сумын ЭМТ 0.1 сая төгрөг/
- Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох арга зүй, стандартын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй буюу анхан шатны баримтын бүрдэл дутуу /Сүхбаатар хөгжил ҮТП 3.4 сая төгрөг, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 2.1 сая төгрөг/
- Шатахууны норматив зардлыг хэтрүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан. /Баруун-Урт сум 9.2 сая төгрөг, Баруун-Урт сум ИТХ 2.8 сая төгрөг/
- Нүүрс тээвэрлэлтийн хөлс олгохдоо жишиг нормативыг мөрдөөгүй. /9 төсвийн шууд захирагч 7.2 сая төгрөг/
- Төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиг багатай зүйлд зарцуулсан /Баруун-Урт сум 4 сургууль 2.2 сая төгрөг, Баруун-Урт сум 7 цэцэрлэг 0.3 сая төгрөг, Халзан сум ЗДТГ 3.5 сая төгрөг/
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд зарим албан хаагчдын цалин хөлснийг зөрүүтэй тайлагнасан /Мөнххаан сум ЭМТ 3.7 сая төгрөг, Эрдэнэцагаан сум ЭМТ 7.5 сая төгрөг, Сүхбаатар сум Цэцэрлэг, ЭМТ 1.9 сая төгрөг/
- Дотоод томилолтын зардлаас төлөвлөгдөөгүй гадаад томилолтод хөрөнгө зарцуулж, төсвийг үр ашиггүй олгосон / Мөнххаан сум ЗДТГ 1.6 сая төгрөг/
- Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас ажилчдад бэлтгэлийн хувцас авч төсвийг үр ашиггүй зарцуулсан /Баруун-Урт сум 7 цэцэрлэг 1.3 сая төгрөг/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Засаг даргын харьяа байгууллагуудын 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 73,231.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 73,231.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 58,042.9 сая төгрөгийг урсгал зардалд, 13,428.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 1,759.8 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 44,776.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 369.0 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 23,838.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4,247.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 43,320.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 303.9 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 22,051.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,647.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого нийт 67,322.9 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулж, орон нутгийн төсөвт 613.9 сая төгрөг, улсын төсөвт 1,414.0 сая төгрөг нийт 2,027.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлд нийт 22.0 сая төгрөгийн 66 алдаа, зөрчил илэрч, 22.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 65 зөвлөмж өгсөн. Үүнд:

- Төсвийн төслийг аргачлал заавар журам, төсвийн хүрээний мэдээгдэлтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй /төсвийн шууд захирагч 8 байгууллага/
- Цөөн малтай өрхийг дэмжиж, малжуулах төслийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн боловч эргэн төлөгдөх нөхцөлөөр захиргааны гэрээг байгуулаагүй байна. / Онгон сум ЗДТГ 22.0 сая төгрөг/
- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжид дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. ЛТЗ-5, ТШЗ -46, ОНӨААТҮГ-5/

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр Хандив тусламжаар 157.9 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,281.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,601.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 297.6 сая төгрөг нийт 4,338.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 92.8 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 13.3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13.3 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 129.6 сая төгрөг, нормативд зардалд 120.7 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 167.8 сая төгрөг, томилолт, зочны зардалд 13.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,006.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,474.9 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 973.4 сая төгрөг нийт 4,046.0 сая төгрөгийг зарцуулж, 292.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргасан.

Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 13 төсвийн төвлөрүүлэн захирагч, 106 төсвийн байгууллага, 16 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 31 тусгай сан, 7 төсөл хөтөлбөр нийт 173 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 154 байгууллага аудитад хамрагдаж, 12 итгэл үзүүлсэн, 7 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй 7 эмийн эргэлтийн сан аудитад хамрагдаагүй.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 72 байгууллагыг түүвэрт хамруулж, 82 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: 69 байгууллагад “Зөрчилгүй”, 13 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт гаргасан.

Хүснэгт № 10. “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байгууллагууд

№	Байгууллагын нэр	№	Байгууллагын нэр
1	Сүхбаатар сумын ТТЗ	8	Түмэнцогт сум ЕБС
2	Баруун-Урт сум ЗДТГ	9	Эрдэнэцагаан сум ЭМТ
3	Дарьганга сум ЗДТГ	10	Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ
4	Байгал, орчин аялал жуулчлалын газар	11	Хайлааст голомт ОНӨААТҮГ
5	Баруун-Урт сум 2-р цэцэрлэг	12	Уртын гэгээ ОНӨААТҮГ
6	Баруун-Урт сум 11-р цэцэрлэг	13	Сүхбаатар хөгжил ҮТП ӨНӨААТҮГ
7	Сүхбаатар сум Цэцэрлэг		

Аудитын илрүүлэлт

